

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 01

Дархан-Уул аймаг

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн
дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, Компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Дархан нэхий ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг (хавсралт №1) баталсугай.

Хоёр. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96.4-д заасныг удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн гүйцэтгэх удирдлагын багаас танилцуулсан тайланг хангалттай гэж үзэн (хавсралт №2) баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

дугаар 02

Дархан-Уул аймаг

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ТУЗ-ийн зардлын төсвийг
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62.1.7, 62.1.13 болон 77 дугаар зүйлийн холбогдох заалтууд болон тус компанийн дүрмийн 7.22, 7.23, 7.25-д заасныг тус тус удирдлага болгон 2021 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг: Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.

Хоёр: Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр доорхи нэр дэвшигчдийг тус тус 1 жилийн хугацаатай сонгосугай.

Ердийн гишүүд:

1. Эрдэнэдалайн Батсайхан
2. Равжаагийн Сүмбэнхүү
3. Далхжавын Батжаргал
4. Хумбагайн Золжаргал
5. Баасангийн Гэрэлмаа

Хараат бус гишүүд:

1. Бат-Очирын Энхнавч
2. Цэдэвсүрэнгийн Алтангэрэл
3. Бямбадашийн Мөнхбаяр
4. Отгоны Мөнхжаргал

Гурав: Дархан нэхий ХК-ийн 2021 оны ТУЗ-ийн зардлын нийт 94.9 сая төгрөгний төсвийг (хавсралт №1) баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 03

Дархан-Уул аймаг

ТУЗ-ээс ХЭХурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлыг
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн холбогдох заалтууд болон тус компанийн дүрмийн холбогдох заалтыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар хэлэлцүүлэхээр оруулсан доорх асуудлуудыг хэлэлцээд, 2021 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг: “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн 2021 оны №02 тоот тогтоолыг баталсугай.

Хоёр: “Өөрийн компанийн хувьцаагаа эргүүлэн авах тухай” ТУЗ-ийн 2021 оны №04 тоот тогтоолыг баталсугай. Зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан хувьцааг зөвхөн өөрийн охин компаниудаас гадна стратегийн хөрөнгө оруулагч нарт худалдаж авах боломжийг нээлттэй байлгахыг компанийн ТУЗ-д зөвшөөрсүгэй.

Гурав: “Алтай як” ХХК-г байгуулах тухай ТУЗ-ийн 2020 оны №13 тоот тогтоолыг баталсугай.

Дөрөв: Компани тусгаарлах тухай компанийн тухай хуулийн 22-р зүйлийг мөрдлөг болгон тус компанийн охин компани болох оёдол, гутлын үйлдвэрлэлийн чиглэлийн Нэхий Гармент ХХК-аас гутлын үйлдвэрийг нь тусгаарлаж, үйл ажиллагааны чиглэлээр нь тусад нь дагнан хөгжүүлэх, үйл ажиллагаагаа нь төрөлжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадавхийг сайжруулах зэрэг зорилгоор тусгаарлах, тусгаарлахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх, шинээр байгуулагдах компанийн эрх, үүрэг, хариуцлагыг нь тодорхой болгож ажиллах бүрэн эрхийг Дархан Нэхий ХК-ийн ТУЗ-д олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ